



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025.05.28 № 37-1/69

танай _____-ны № _____-т

Итгэл хүлээлгэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан хамтарсан Засгийн газар нь 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Үндэсний баялгийн сан, хөгжлийн 14 мега төсөл, эрчим хүчний салбарын реформ, бүсчилсэн хөгжил зэрэг томоохон зорилтуудыг "Хурдтай хөгжлийн төлөөх Зориг" уриан доор хэрэгжүүлж, эхний бодит үр дүнг гарган ажиллаж байгаа боловч үүссэн улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан цаашид сонгодог парламентын тогтолцоог төгөлдөршүүлэх, дэвшүүлсэн бодлого, зорилтоо тогтвортой, тууштай хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Ерөнхий сайд миний бие хамтын хариуцлагын зарчим, улс төрийн соёлын хувьд Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхийг хүндэтгэн, итгэл хүлээлгэх эсэх асуудлыг ард түмний төлөөллийн төв байгууллагаар шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Асуудлыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД
ИТГЭЛ ХҮЛЭЭЛГЭХ ТУХАЙ**

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1, 102.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Хурдтай хөгжлийн төлөөх Зориг” уриан доор хэрэгжүүлж байгаа Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Үндэсний баялгийн сан, хөгжлийн 14 мега төсөл, эрчим хүчний салбарын реформ, бүсчилсэн хөгжил зэрэг томоохон зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлж, бодит үр дүнг бататгах, цаашид дэвшүүлсэн бодлого, зорилтоо хамтын хариуцлагын зарчимд тулгуурлан тогтвортой хэрэгжүүлэх шаардлагыг харгалзан хамтарсан Засгийн газрын бодлогыг дэмжиж, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд итгэл хүлээлгэхээр тогтсугай.

2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл
хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын
тогтоолын төсөл

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнд бүрдсэн 126 гишүүнтэй парламентад ард түмний дэмжлэг авсан улс төрийн намуудад өгсөн сонгогчдын саналыг гээхгүй байх суурь зарчимд үндэслэн, үндэсний эрх ашгийг нэгдүгээрт тавьж, Монгол Ардын нам Засгийн газрын бүрэлдэхүүнд Ардчилсан нам, ХҮН намыг урьж хамтарсан Засгийн газрыг байгуулсан.

Түүнчлэн, улс орны хөгжлийн тулгамдсан асуудал, сорилт бэрхшээлийг хурдтай, үр дүнтэй шийдвэрлэх, бүрэн эрхийнхээ хугацаанд бүтээлчээр, тогтвортой хамтран ажиллах зорилгоор “ХУРДАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” уриан доор хамтарсан Засгийн газрын гэрээг байгуулсан.

Тус гэрээг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуульд дэвшүүлсэн Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын мөрийн хөтөлбөрт суурилан боловсруулж, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөгжлийн мега төслүүдээ гацаанаас гарган, хэрэгжүүлж эхэлсэн.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан Үндэсний баялгийн сан, хөгжлийн 14 мега төсөл, эрчим хүчний салбарын реформ, бүсчилсэн хөгжил зэрэг томоохон зорилтуудыг цаашид үр дүнтэй, тогтвортой хэрэгжүүлэхэд хамтын хариуцлагын зарчим нэн чухал юм.

Хамтарсан Засгийн газрын гэрээнд “...улс төрийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд талуудын намын төлөөллийн төв байгууллагаар хэлэлцэж эцэслэн шийдвэрлэнэ” гэж заасны дагуу Монгол Ардын Намын Бага Хурлаас 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 4 дүгээр тогтоолыг баталж, хамтарсан Засгийн газрын гэрээг зөрчсөн улс төрийн намыг оролцуулахгүйгээр Засгийн газрыг бүрдүүлэх шийдвэрийг гаргасан.

Өөрөөр хэлбэл, хамтарсан Засгийн газрыг байгуулсан улс төрийн нэг хүчин Засгийн газраас гарах нөхцөл байдал үүссэн тул Ерөнхий сайд миний бие хамтын хариуцлагын зарчим, улс төрийн соёлын хувьд Улсын Их Хурлын бүрэн эрхийг хүндэтгэн, итгэл үзүүлэх эсэх асуудлыг ард түмний төлөөллийн төв байгууллагаар шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна” гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар Улсын Их Хурлын итгэлийг хүлээсэн байвал зохино” гэж тус тус заасан.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу цаашид хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн бодлого, зорилтыг тууштай хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг

шаардлагатай байгаа тул "Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэхээр хүргүүлж байна.

Тогтоолын төсөл нь Ерөнхий сайдад Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хуралд оруулж байгаа асуудал тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.9 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 38.9 дэх хэсэгт заасны дагуу хууль тогтоомжийн үзэл баримтлал боловсруулан батлах, судалгаа, үнэлгээ хийх болон олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах шаардлагагүй болно.

Тогтоолын төсөл нь нийт 2 заалттай бөгөөд 1 дэх заалтаар Улсын Их Хурлаас Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай, 2 дахь заалтаар тус тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тогтоосон агуулга бүхий зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасантай нийцүүлэн тусгасан.

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, холбогдох бусад хуультай уялдсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 35, 36 дугаар зүйлд заасан шаардлагыг ханган боловсруулсан болно.

---oOo---